



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 18 өдөр

Дугаар А/81

Ховд

Тогтоолын хэрэгжилт хангах тухай

Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.5 дахь заалт, Улсын нөөцийн тухай хуулийн 13.1.4 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 449 дүгээр тогтоол, 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 479 дүгээр тогтоол, Улсын нөөцөөс бараа материал гаргах нөхөн бүрдүүлэх тухай тогтоол, аймгийн Онцгой комиссын 2024 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ховд аймгийн Онцгой байдлын газрын 100 дугаар салбараас 50 хувь хямдруулан олгох 170 тн тэжээлийг Булган суманд 70 тн, Үенч суманд 50 тн, Алтай суманд 50 тонныг тус тус олгосугай.

2. Улсын нөөцөөс 50 хувийн хямдралтай олгох тэжээлийн төлбөрийг Онцгой байдлын ерөнхий газрын 100900031005 тоот дансанд төвлөрүүлж өр, авлага үүсгэхгүйгээр зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Онцгой комиссын орлогч, Баруун бүсийн төв- Ховд аймгийн Онцгой байдлын газрын дарга (хурандаа Б.Алтанбадралт)-д үүрэг болгосугай.

3. Улсын нөөцөөс 50 хувь хямдруулсан тэжээлийг малчид, мал бүхий иргэдэд олгох ажлыг удирдлагаар хангаж, тэгш хүртээмжтэйгээр хуваарилан олгохыг Алтай, Үенч, Булган сумдын Засаг дарга нарт даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Баруун бүсийн төв-Ховд аймгийн Онцгой байдлын газрын дарга (хурандаа Б.Алтанбадралт)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б. БОЛОРМАА

8400001 0185 Заг А/81-а